

“УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр

№	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ	ЗААЛТ	БИЕЛЭЛТ	ХУВЬ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ-3				
1	2022-01-05 №1	“Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлах тухай”	Тус байгууллага нь ажилтнуудыг халдвараас сэргийлэх дэглэм баримтлан шаардлагатай үед амны хаалт зүүх болон хүн хоорондын зай барих, урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг гэрээт байгууллага болох “Гангаболд” ХХК-тай хамтран нийт 22 өрөө, тасалгааны 210м2 талбайд болон арчлалтын ажлыг хариуцдаг БЗД 7-р хороо Сансарын нүхэн гарц, 1-р хороо шилэн гүүрэн гарц, СБД 8-р хороо 100 айл, ЧД 2-р хороо Бөмбөгөр, ХУД 1-р хороо 120 мянгат, 2-р хороо 19-н гүүрэн гарцуудад ариутгал улирал бүр, цэвэрлэгээ тогтмол хийгдсэн. Халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй, ажилтан албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалан ажилласан. Нийт ажилтнуудын 96% дархлаажуулалтын нэмэлт тунд хамрагдсан.	100%
2	2022-02-17 №43	“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”	Хэрэгжилтийг хангах хүрээнд сахилга батыг сайжруулж, байгууллагын үргүй зардлыг багасгахад чиглэсэн дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд: Шинээр ажлын байр бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлээгүй, авто машин, албан конторын тавилга, үндсэн хөрөнгө худалдаж аваагүй, салбарын хэмжээнд сургалт, семинар, хурал зөвлөлгөөн болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэж, баяр ёслол, тэмдэглэлт ой, аялал зугаалга зэргийн зохион байгуулаагүй байна.	100%

3	2022-05-25 №204	“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”	Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашиныг тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн авто машин хүлээлцэх актаар 04-55УНЛ Sonata-6 маркийн авто машиныг Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ-т хүлээлгэн өгөв. Үүнтэй холбогдуулан хариуцсан жолоочийг шилжүүлэн үргэлжлүүлэн ажиллуулахаар арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн.	100%
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ-25				
1	НЗД-ын 2022-01-03 А/01 2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарлах тухай	Нийслэлийн иргэдэд хотын соёлыг төлөвшүүлэх, дүрэм, стандартыг сурталчлах, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах, эрүүл мэндийг анхаарах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодит үр дүнд хүрэхүйц ажлыг санаачлан зохион байгуулж, ажиллах	Уг захирамжийн дагуу батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6 зорилтын хүрээнд нийт 10 арга хэмжээний биелэлтийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст албан бичгийн хавсралтаар болон цахим хаягаар хүргүүлэн ажилласан.	100%
2	НЗД-ын 2022-02-14 А/180 Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтыг “Шар түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан хүн, хуулийн этгээдийн бүх төрлийн үйл ажиллагааны хязгаарлалтыг цуцалсугай. 2.“Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасныг	Захирамжийн хэрэгжилтийг ханган ажилтнуудыг халдвараас сэргийлэх дэглэм баримтлан шаардлагатай үед амны хаалт зүүх болон хүн хоорондын зай барих, урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, ариутгал тогтмол хийгдэж байна. Халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй, ажилтан албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалан ажилласан. Нийт ажилтнуудын 96% дархлаажуулалтын нэмэлт тунд хамрагдсан.	100%

		баримтлан халдвар хамгааллын дэглэм сахиж, амны хаалт зүүж, гараа тогтмол ариутгаж байх, дархлаажуулалтад бүрэн хамрагдах		
3	НЗД-ын 2022-02-17 А/212 Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай	1.1.Мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүхий л үе шатанд тавих хяналтыг сайжруулж ажиллах 1.6.ХАА-г зохион байгуулахад шаардлагатай техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг 2022.02.25-ны өдрийн дотор хаа-г зохион байгуулах байгууллагад хүргүүлэхийг захиалагчийн хяналт тавих 1.7.Тендер шалгаруулалтыг 2022.03.01-ний өдрийн дотор зарлаж дуусгах	1.1 Нийслэлээс захирамжаар эрх шилжиж ирсэн авто зам засвар арчлалтын ажлуудыг стандартын дагуу гүйцэтгэж хяналт тавин ажиллаж байна. 1.6 Нийслэлийн Засаг даргын А/248, А/266, А/515, А/551, А/664, А/674, А/740, А/826, А/880, А/889, А/890 захирамжаар төсөл арга хэмжээнүүдийн эрх шилжиж ирсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.12 “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсэн заалтын дагуу ажлаа гүйцэтгэн ажиллаж байна. 1.7 2022 оны 04-р сарын 01-ны өдрийн А/467 тоот захирамжаар эрх шилжиж ирсэн машин тоног төхөөрөмж худалдан авах нээлттэй цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллаж нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан.	100%
4	НЗД-ын 2022-02-23	НЗСХ-өөр 2022 онд санхүүжих зам талбайн	Багц-11, Багц-12 хотын гол болон туслах гудамж замуудын засвар, арчлалтын ажлын хүрээнд 8050м2 талбайд авто замын	100%

	А/248 Эрх шилжүүлэх тухай	тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх	эвдрэл засварлаж асфальтбетон нөхөөс Гүнтийн даваа чиглэлийн авто замын засвар арчлалтын ажил- 1000м2 БЗД, Улиастайн гүүрийн хэв гажилтын заадсанд 4 у/м метал хийц шинээр суурилуулж бэхэлгээ хийх ажил тус тус хийгдсэн.	
5	НЗД-ын 2022-03-11 А/369 “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ- ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай	1.“УБЗЗАГ” ОНӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2.Бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан ажиллагсдын цалин хөлс, нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоож ажиллах	Уг захирамжаар тус байгууллага нь бүтцийн 6 нэгжтэй, нийт 199 орон тоотой байхаар шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг Даргын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/657 дугаар захирамжийн дагуу 2 Орлогч даргын орон тоог хасч, нийт орон тоо 197 болсон.	100%
6	НЗД-ын 2022-04-01 А/467 Эрх шилжүүлэх тухай	НЗСХ-өөр 2022 онд санхүүжих авто замын засвар, арчлалтын машин механизм, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авах эрхийг УБЗЗАГ-т шилжүүлэн, холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллах	Холбогдох хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ хийгдэн 8 ширхэг техникийг худалдан авсан	100%
7	НЗД-ын 2022-04-14 А/515 Хөрөнгө гаргах тухай	Нийслэлийн иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор хашаа буулгах	СБД. 1-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Үндэсний соёл, амралтын хүрээлэнгийн гадна талын 720у/м хашааг буулгах ажил хийсэн	100%
8	НЗД-ын 2022-04-22 А/551	Газар албадан чөлөөлж, явган хүний болон дугуйн	БЗД, 26-р хорооны нутаг дэвсгэр, Оргил худалдааны төвийн баруун талын явган замын ажлын хүрээнд: явган хүний болон	100%

	Газар албадан чөлөөлж, явган хүний болон дугуйн зам барих тухай	зам барих ажил	дугуйн замын ажил: Хавтан-156м2, Хашлага-110 у/м, Хучилт-82.72м2	
9	НЗД-ын 2022-04-27 А/578 Ажлын хэсэг байгуулах тухай	Биеийн давхцалгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг цуглуулахад үндэслэл болгосон дүрэм, журмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуультай нийцүүлэн нэн даруй зохион байгуулж, тайлагнах	Цаг бүртгэлийн системд ашиглаж байсан нийт 176 хэрэглэгчийн 19905 удаагийн танилт бүхий хурууны хээний өгөгдлийг бүрэн устгаж, тайлан мэдээг НЦХМТГ-ын дарга О.Чинзориг, УБЗАА-ны Мэдээллийн технологи, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэболд нарт егр системээр илгээсэн болно.	100%
10	НЗД-ын 2022-05-11 А/657 Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай	НЗД-ын 2022 оны А/369-р захирамжаар бүтэц, орон тооны хязгаар 199 хүртэл, үүнээс Удирдлага-4 гэснийг 197 хүртэл, үүнээс Дарга-1, Ерөнхий инженер-1	2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Б/116 тоот тушаалаар Орлогч дарга Д.Уламсайханыг, Б/117 тоот тушаалаар Б.Алгааг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн.	100%
11	НЗД-ын 2022-05-20 А/674 Хашаа буулгаж, явган хүний болон дугуйн зам барих тухай	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах	ХУД, 15-р хороо, Зайсангийн гудамжинд байрлах “Богд хааны ордон музейн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжуудыг тойрсон бетон суурьтай төмөр хашааг нурааж, явган хүний болон 522м2 /0.348км/ дугуйн зам барих ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
12	НЗД-ын 2022-05-24 А/699 “Улаанбаатар Марафон-2022” олон улсын гүйлтийн тэмцээн зохион байгуулах талаар авах зарим	2.2.Автомашинны хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарласан замын гарцыг хааж, хамгаалалтын болон нэмэлт тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, замын эвдрэл гэмтлийг засварлах арга хэмжээг	1.Авто замын нүхэн эвдрэл засварлах нөхөөсний ажлыг СБД, Олимпийн гудамжинд 2 байршилд, ЭТӨЧ Зүүн дөрвөн замаас-Төв шуудангийн уулзвар хүртэл 7 байршилд, БЗД Токиогийн гудамжинд 1 байршилд, Сансарын туслах замд 9 байршилд, БГД Сөүлийн гудамжинд 2 байршилд нийт 47.51м2 асфальтбетон хольцоор нөхөөс хийсэн. 2. Авто зам хаах ажлын хүрээнд 35 ширхэг түр тэмдэг, 763 у/м хайс байршуулах ажлууд тус тус хийгдлээ.	100%

	арга хэмжээний тухай	шуурхай зохион байгуулах		
13	НЗД-ын 2022-06-09 А/789 Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай	ННЗБ болон НӨТ, ААТБ тэдгээрийн харьяа орон нутгийн өмчит үйлдвэрийн газраас төвлөрүүлсэн суудлын автомашиныг авто баазад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах	Батлагдсан хуваарийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн авто машин хүлээлцэх актаар 04-55УНЛ Sonata-6 маркийн авто машиныг Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ-т хүлээлгэн өгөв.	100%
14	НЗД-ын 2022-06-16 А/826 Эрх шилжүүлэх тухай	НТХ-өөр 2022 онд санхүүжих ХУД, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн авто замын засварын ажлыг хийж гүйцэтгэх	ХУД, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн авто замын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
15	НЗД-ын 2022-06-27 А/740 Дархан цаазат Богд хан уулын байгаль орчны тэнцвэрт байдал, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах	Хан-Уул дүүрэг 11 дүгээр хороо, Ар зайсангийн гудамж, Дугуй цагаан орчимд байрлах 53ш шавар гэр нураах ажил гүйцэтгэсэн	100%
16	НЗД-ын 2022-06-29 А/880 Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зарим арга хэмжээний тухай	Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай болон иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газарт зохих зөвшөөрөлгүй байрлуулсан, хийц бүтээцэд нь ан цав, цууралт үүсэж, эвдэрч,	Нийт 363 ширхэг самбар буулгах ажил хийгдсэн.	100%

		гэмтсэн зар сурталчилгааны болон бусад төрлийн самбар, хөшөө, суварга, эд зүйлсийг албадан буулгаж, газар чөлөөлөх		
17	НЗД-ын 2022-07-01 А/889 Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай	2022 онд авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн баруун урд хэсгийн авто зогсоолын ажлын хүрээнд 1.8 км асфальтбетон хучилт/ хийгдсэн	100%
18	НЗД-ын 2022-07-01 А/890 Эрх шилжүүлэх тухай	ХХААХҮЯ-ны хойд тал,СЭЗИС-руу орох зам талбайн засвар арчилгаа,тохижилтын ажил	Асфальтбетон хучилт байгуулах-1160м2 хавтан-100м2, хашлага-190у/м, шүүрт худаг-6ш	100%
19	НЗД-ын 2022-07-25 А/994 Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай	АШУҮИС-ийн төв байрны авто зогсоол, талбайн тохижилтын ажил	АШУҮИС-ийн төв байрны авто зогсоол, талбайн тохижилтын ажлын хүрээнд явган замын хавтан суурилуулж 1450м2 асфальтбетон хучилт байгуулах ажил хийж гүйцэтгэсэн.	100%
20	НЗД-ын 2022-08-15 А/1049 Журам шинэчлэн батлах тухай	Иргэдээс ННЗБ-ын дотоод удирдлагын UB ERP нэгдсэн систем дэх Өргөдөл, гомдлын дэд системд хөгжүүлэлт хийж, шийдвэрлэлтийн үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулах	2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 76 өргөдөл хүсэлт ирснийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “UB ERP” Дотоод удирдлагын систем дэх өргөдөл, гомдлын цэсэнд бүртгэж хянан, холбогдох ажилтанд шилжүүлж хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэн ажилласан. Үүнд: ❖ Хүсэлт-69 ➤ Байгууллагын албан хаагчид-60, Иргэн-9 ➤ E Service-1 ➤ 11-11 төв-2 ❖ Гомдол-6: 1800-1200 дугаарт-4, гар утасны	100%

			аппликейшнээр ирсэн-2 ❖ Санал-1: НҮНТ-д бүртгэсэн-1	
21	НЗД-ын 2022-08-16 А/1067 Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай	НЗСХ-өөр 2022 онд санхүүжих Сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах	БЗД. Цагдаагийн академийн өргөн чөлөөний гудамж. 62-р цэцэрлэгийн урд талбайн зогсоолын ажлын хүрээнд 210у/м хашлага, 1500м2 асфальтбетон хучилт байгуулсан.	100%
22	НЗД-ын 2022-08-23 А/1106 Журам шинэчлэн батлах тухай	ННЗБ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	1.Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны жилийн эцсийн биелэлт 2.ЗГ-ын үйл ажиллагааны 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт 3. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний биелэлтийг 14 хоног тутамд Пүрэв гарагт тус тус тайлагнасан.	100%
23	НЗД-ын 2022-09-30 А/1261 Захирамжийн хавсралтыг шинэчлэн батлах тухай	Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай НЗД-ын А/664 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтыг шинэчлэн батлах тухай	Нийт 13 гудамж замд 17.353м2 явган замын ажил хийгдсэн.	100%
24	НЗД-ын 2022-10-11 А/1322	Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй байрлуулж, эвдэрч гэмтсэн зар сурталчилгааны самбар болон барилга байгууламжуудыг албадан буулгаж, газар чөлөөлөх	Шавар гэр-56ш Байшингийн дээвэр-1ш Чулуун хашаа-110у/м Торон хашаа-240 у/м Хог хаягдал-900м2 Самбар 338ш	100%
25	НЗД-ын 2022-10-21 А/1357 Өндөржүүлсэн бэлэн байдлын	Нийслэлийн агаар орчныг бууруулах, сайжруулсан шахмал түлшний ханган нийлүүлэлттэй холбоотой асуудлаар гаргасан	Захирамжийн хэрэгжилтийг ханган байгууллагуудын хамтын ажиллагаа, шуурхай удирдлага, зохицуулалтыг эрчимжүүлэх ажлын батлагдсан төлөвлөгөөний дагуу Баянзүрх дүүргийн 13, 14, 42-р хороодын сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, түүхий нүүрсний хяналт шалгалтын ажилд хамтран ажиллаж	100%

	зэрэгт шилжүүлэх тухай	шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ тухай бүр авч ажиллах	өдөр бүр Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын Шуурхай штабын дугаар утсанд мэдэгдэж, хүснэгтийн дагуу мэдээллийг Хяналт зохицуулалтын ажилтан Г.Номинд илгээн ажилласан.	
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ-10				
1	2022-01-28 №02/04	1."Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд удаашралтай, эрчимжүүлж ажиллах шаардлагатай арга хэмжээнүүдийг 2022 оны зорилтод түвшинд хүргэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад	6.3.6. Авто зогсоолыг шинээр барих, шинэчлэх ажлын хүрээнд:СХД, 18-р хороо 21-р хороолол 43 машины зогсоол барив 6.3.7. Нийт 13 гудамж замд 17.353м2 явган замын ажил хийгдсэн. -ХУД, 15-р хороо, Зайсангийн гудамжинд байрлах Богдханы ордон музейн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж тойрсон бетон суурьтай төмөр хашааг буулгаж, 522м2 дугуйн зам барих ажил гүйцэтгэсэн.	100%
2	2022-01-13 №01/02	1. "Нийслэлийг 2021-2015 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах, удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны зорилтод түвшинд хүргэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад	"Нийслэлийг 2021-2015 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" Зорилт 9.19. НЗД-ын Захирамж 2022.02.23 А/248. Хотын гол болон туслах гудамж замуудын засвар, арчлалтын ажлын хүрээнд ХУД, БЗД-т нийт 20,550м2 талбайд авто замын нүхэн эвдрэлийг асфальтбетоноор засварлав	100%
3	2022-01-13 №01/01	1."Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр" болон "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах, удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны зорилтод түвшинд хүргэх	ХУД, БЗД-т нийт 20,550м2 талбайд авто замын нүхэн эвдрэлийг асфальтбетоноор засварлав	100%

4	2022-06-10 №10/07	Уулзваруудыг дахин инженерчлэн, хөдөлгөөн зохион байгуулалтыг өөрчлөн нэвтрүүлэх чадварыг сайжруулах	БЗД."Саруул тэнгэр" хотхоны хойд талын 0.23км авто замын ажлын хүрээнд: Суурийн дүүргэлт, нарийн тэгшилгээ хийж 1050м2 талбайд асфальтбетон хучилт, 430у/м хашлага суурилуулсан.	100%
5	2022-06-10 №10/08	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203-р тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөн"-нд тусгагдсан НЗДТГ хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хэрэгжилтийг 2022 оны зорилтот түвшинд хүргэх	Явган болон дугуйн замын сүлжээг нэмэгдүүлэх ажлууд хийгдсэн. Үүнд: БЗД, 26-р хороо Хүннүгийн гудамж-1.2км, Бага тойруу В блок-2240м2, С блок-2940м2, Е блок-230м2, Г блок-1098м2, I блок-800м2, ICC Tower-900м2 тус тус явган замын шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэсэн.	100%
6	2022-06-30 №11/08	Хяналтад авагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийг хангах, удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах	2022 онд хийж гүйцэтгэх гэрээт ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдсэн бөгөөд удаашралтай эрчимжүүлэх арга хэмжээ байхгүй.	100%
7	2022-07-06 №11/01	Стандарт, норм, дүрмийг шинээр санаачлах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа бодит судалгаа, тооцоонд үндэслэн боловсруулж, Хотын стандарт, хяналтын газарт 2022.09.01-ний өдрийн дотор хүргүүлэх	Явган хүний зам, талбайн төлөвлөлт, техникийн шаардлага MNS6808:2019. 5.6.5.2 стандартад өөрчлөлт оруулах тухай саналыг Хотын стандарт, хяналтын газарт хүргүүлсэн.	100%
8	2022-07-06 №11/03	Өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар санаачлагатай, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах, хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгэх, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай захиран зарцуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65-р тогтоолоор батлагдсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгож ажиллах	Байгууллагын өмч хамгаалах комисс 2022.05.20-ны өдөр хуралдаж, ашиглах, засварлах боломжгүй болсон 5 ширхэг тээврийн хэрэгслийг актлах санал гарган НӨАУГ-т актлах саналыг хүргүүлсэн. Мөн 2022 оны Төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно гэх	100%

			хуулийн хэрэгжилтийн дагуу тээврийн хэрэгслийг НӨАУГ хураалгах шийдвэр гарган хүлээлгэн өгсөн.	
9	2022-07-06 №11/04	“Хотын иргэний жил”-ийн хүрээнд иргэдийн амьдрах орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн төлөвлөгөөний дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг иргэд олон нийтэд сурталчлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах	“Хотын иргэний жил”-ийн хүрээнд иргэдийн амьдрах орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6 зорилтын хүрээнд нийт 10 арга хэмжээний биелэлтийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст албан бичгийн хавсралтаар болон цахим хаягаар хүргүүлэн ажилласан.	100%
10	2022-07-06 №11/06	<p>1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 187-р тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэдээс гаргасан саналын шинжтэй өргөдлийг судалж, байгууллагын бодлого, шийдвэрт тусгах, хэрэгжилтийг тайлагнаж, байгууллагын цахим хуудсанд сар бүр мэдээлж ажиллах</p> <p>2.Иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдолд 7 хоног бүр шинжилгээ хийж, хандалтаар тэргүүлж байгаа агуулгын шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлон, түүнийг арилгах чиглэлээр холбогдох арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх</p> <p>3.Иргэдээс ННЗБ, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан бичгээр өгч хэвших</p> <p>4.Өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллах</p> <p>5.Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад тайлагнаж ажиллаагүй</p>	<p>1.2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 иргэнээс саналын шинжтэй өргөдөл ирүүлсэнийг хүлээн авч, шийдвэрлэсэн.</p> <p>2.Иргэнээс ирсэн 17 өргөдөлд шинжилгээ хийж хандалт их байгаа авто замын эвдрэл, гэмтлийн тухай гомдлын дагуу холбогдох хэлтэст шилжүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган засварлаж шийдвэрлэсэн.</p> <p>3. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан.</p> <p>4.Иргэд, аж ахуйн нэгж, ажилтан албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>5. Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны</p>	100%

		албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах	байгууллагад тайлагнаж ажиллаагүй зөрчилгүй байна.	
--	--	--	--	--

ХЯНАСАН:
ДАРГА

Б.ГАЛХҮҮ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.АРИУНБОЛД

НЭГТГЭСЭН:
ДОТООД АЖЛЫН МЭРГЭЖИЛТЭН

Ж.МӨНХЖАРГАЛ